



Р.УУГАНБАЯР

*Хууль сахиулахын их сургууль
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Аюулгүй байдлын
тэнхимийн багш, ахмад*

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЯЛТНЫ ҮЙЛДЭХ ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 45.3-д эрүүгийн хариуцлагын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

1. Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах;
2. Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх;
3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цэрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино⁷³.

Хорих ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл бол эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах явдал мөн. Хорих байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох хорих ял эдлэгсдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдал нь дэглэмийн хэрэгжилт харуул хамгаалалтын үйл ажиллагаанаас шууд хамаарана.

Хорих ангид үйлдэгддэг гэмт хэргийг хамаарах субъектээр нь:

1. Ялтны зүгээс үйлдэгдэх гэмт хэрэг;
2. Албан хаагчийн зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг;
3. Хорих ангийн орчинд бусад этгээдээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг гэж ангилна.

Түүнчлэн хорих ангид гарч буй гэмт явдлыг төрлөөр нь буюу нийтлэг давтамжаар нь:

1. Ял эдлэхээс зайлсхийх буюу оргох гэмт хэрэг;
2. Хүч хэрэглэсэн гэмт хэрэг;
3. Өмчийн эсрэг гэмт хэрэг ;
4. Бэлэгсийн гэмт хэрэг ;
5. Нийтийг хамарсан зохион байгуулалттай гэмт явдал;

⁷³ Монгол улсын Эрүүгийн хуулийн 45-р зүйл 45.3- дахь заалт

6. Бусад гэмт хэрэг гэх мэт ангилж болно.

Хорих байгууллагын хэмжээнд гарч болзошгүй гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудал бол хорих байгууллагын төрөл дэглэм, гэмт явдлын төрлийг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм. Иймд судлаачийн зүгээс уг асуудлын хамрах хүрээг багасгаж хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгайлан авч үзэхээр шийдсэн болно.

Хүч хэрэглэсэн гэмт явдал гэдэг нь бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг тодорхой сэдэл зорилгын үүднээс \ шунахай, танхай, өс хонзон, захиалгаар гэх мэт \ бие махбодь, сэтгэл зүй, эрх мэдэл зэрэг давуу байдлаа илтээр ашиглан зөрчих гэмт хэрэг зөрчлийн нийлбэр цогцыг хэлнэ⁷⁴.

Хүч хэрэглэсэн хүнд гэмт хэрэг гэсэн ойлголтод бие хүний амь нас, эрүүл мэнд, бие махбодь, бэлгийн халдашгүй байдлын эсрэг чиглэсэн хор аюул нөлөө их, тодорхой бүлэг хэргүүд хамаардаг. Тухайлбал, бусдыг санаатай алах, бусдын бие мах бодид санаатай хүнд гэмтэл учруулах, танхайрах, хүчиндэх гэмт хэргүүд хамаарна.

Хорих ялын төрөл, дэглэмүүдэд ял эдэлж буй ялтнуудын хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэгт анализ хийж үзэхэд жирийн дэглэмтэй хорих ангиудад хүч хэрэглэсэн гэмт хэрэг гарах явдал харьцангуй бага байдаг бол чанга, онцгой дэглэмтэй хорих ангид үйлдэгдсэн хүч хэрэглэсэн гэмт хэрэг харьцангуй их гардаг байна. Чанга онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлэгсэд ихэвчлэн олон жилийн ялтай онц хүнд гэмт хэрэгтнээр тооцогдсон, рецидив, мэргэжсэн гэмт хэрэгтнүүд байдаг бөгөөд олон жил, давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж бие биетэйгээ ижил дасал болсон найз нөхөд, гал хамын холбоо гүн гүнзгий хүчтэй байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газраас нэгтгэсэн сүүлийн 5 жилийн статистик тоон судалгаанаас үзвэл хорих байгууллагад ялтны зүгээс 2009 онд 19 гэмт хэрэг, 2010 онд 18 гэмт хэрэг, 2011 онд 9 гэмт хэрэг, 2012 онд 24 гэмт хэрэг, 2013 онд 24 гэмт хэрэг тус тус үйлдэгдсэн байна. Аливаа гэмт хэрэг, гэмт явдлын шалтгаан, нөхцлийг судлан үзэж, мөн чанарыг таньж мэдснээр түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга замыг зөв оновчтой хийх онолын болон практик ач холбогдолтой байдаг. Криминологийн шинжлэх ухаанд гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг онолын үүднээс дараах байдлаар тайлбарласан байдаг байна.

“Гэмт явдлыг үүсгэж, оршин байлгаж, түүнийг өсгөж буюу бууруулж байдаг нийгмийн амьдралын тэрхүү үзэгдлийг гэмт явдлын **шалтгаанууд гэнэ**”⁷⁵

Гэмт хэргийг шууд үүсгэдэггүй, харин байгаа байдлаараа гэмт хэрэг үйлдэх

74 Г.Эрдэнэбат, Б.Батзориг, Г.Туяа “Криминологи” гарын авлага УБ. 2013 он. 29 дэхь тал

75 Ж.Болобаатар, О.Нялмдаваа “Криминологи” сурах бичиг УБ 2010 он.89 дэхь тал

бодол санааг хүнд бий болгоход нөлөөлдөг бодит баримтаг байдлыг гэмт хэрэг гарахад үйлчилдэг нөхцлүүд гэж ойлгоно.”

Хорих байгууллагад ялтны зүгээс үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл. Үүнд:

1. Нийтлэг шалтгаан

Хорих ангийн дотор өөрийн байр сууриа олох, нөлөөгөө тогтоох хүсэл эрмэлзэл зэргээс үүдсэн ялтан хоорондын зөрчилдөөн

2. Бусад шалтгаан

- Хорих ангийн ахуй нөхцөл болох ялтны орон байрны хүрэлцээ, хоол хүнс, бие хүний физиологийн хэрэгцээ
- Ялтан хоорондын харилцаа болох хамт ял эдлэгсдийгээ дарамтлах, эрхшээлдээ оруулах гэсэн үйл ажиллагаа, ялтан хоорондын харилцаанд үүсдэг ахуйн хүрээний маргаан, өс хонзон гэх мэт
- Улс төрийн тогтворгүй байдал, хууль, эрх зүйн тогтворгүй байдал, ядуурал, ажилгүйдэл зэрэг шалтгаанаас үүдэлтэй байна.

1. Хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлд:

Хорих ангийн харуул хамгаалалтын албан хаагчийн ажлын хариуцлага, сонор, сэрэмж, ажилдаа хандах хандлага, харуул хамгаалалтанд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслийн хүчин чадал, бүрэн бүтэн байдал.

Аливаа гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг үйлдэгдсний дараа биш, үйдэгдэхээс нь өмнө харж урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөв оновчтой зохион байгуулах нь гэмт хэргийг тогтворжуулах, таслан зогсоох онцгой ач холбогдолтой.

“ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа гэдэг нь гэмт явдлын онцлог, түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, хохирогч, гэмт бие хүн, тэдгээрийн онцлог, төлөвшин тогтох зүй тогтол, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний нийгэмд болон гэмт явдалд нөлөөлж буй байдал, үр дүнг судалсны үндсэн дээр гэмт явдлыг бууруулах, саармагжуулах, тогтворжуулах, таслан зогсоох, устгахад чиглэгдсэн нийгэм эдийн засаг, улс төр, хууль эрх зүйн цогц үйл ажиллагаа юм⁷⁶.”

Хорих ял эдлүүлэх байгууллагад ялтны зүгээс үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг ялтны төрөл, дэглэм, гүйцэтгэх ажлын нөхцөл байдал, ялтны тоо, алба хаагчдын хүч хэрэгслийг харгалзан зөв оновчтойгоор зохион байгуулах явдал юм. Хорих ял эдлүүлэх байгууллага дахь хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

1. Хорих байгууллагын харуул хамгаалалтын албаны үйл ажиллагааны чиглэлээр

76 Г.Эрдэнэбат, Б.Батзориг, Г.Туяа “ Криминологи ” гарын авлага УБ. 2013 он. 38 дахь тал

- Харуул хамгаалалтын ажилтнуудын хариуцлага, бие бялдрын хөгжил, мэдлэг, хувийн зан чанар, харилцааны хэв шинжийг онцгой нягтлан сонгох өндөр мэдлэг боловсролтой, ажиллах сонирхолтой боловсон хүчинг бий болгох, мөн сургалтыг оновчтой хэлбэрээр зохион байгуулах

- Хорих ангийн харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа ээлжийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх хамгаалалт, жижүүрлэлтийн цагийг богиносгох, хоногт жижүүрлэх бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх, харуулын алба хаагчдын ээлжийн бие бүрэлдэхүүний цагийг богиносгож 8-16 цагаар 4 ээлж байхаар зохион байгуулах. Ингэснээр жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд ядрах, назгайрах, нүд дасах зэрэг дутагдлаас урьдчилан сэргийлэх боломжтой юм.

- Хорих ангийг орчин үеийн холбоо дохиоллын техник, хэрэгслээр бүрэн хангах ажилтнуудын энэ талын мэдлэгийг дээшлүүлэх.

- Хорих ангийн харуул хамгаалалтанд албаны нохойг өргөнөөр ашиглах

2. Гүйцэтгэх ажлын чиглэлээр

- Хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэж байсан болон, үйлдэж болзошгүй ялтны талаар нарийвчилсан судалгааг гүйцэтгэх ажилтнууд өөрсдийн хорих ангийн онцлогт тохируулан хийх

- Хорих байгууллагын гүйцэтгэх ажилтанг давтан сургах

3. Ялтны дунд явуулах нийгэмшүүлэх ажлын чиглэлээр:

- Ялтан бие хүний сэтгэхүй, зан байдлын онцлог, оюуны болон биеийн нөөц чадавхид тулгуурлан ганцаарчилсан уулзалт хийх, нийгэмшүүлэх ажлын хүрээнд зөвлөгөө өгөх

- Ардын уламжлалт зан үйл, ёс заншил, үндэсний өв соёл, нийгэм, соёлын үнэт зүйлс, шашины зарим ашигтай зан үйлд тулгуурлан ажиллах.

- Төрөл бүрийн мэргэжил олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах

- Гэмт хэргийн хор уршгийн талаар яриа танилцуулга тогтмол хугацаанд ялтнуудын дунд зохион байгуулах зэрэг болно.